

ИХ ХҮРЭЭНИЙ АРД ОЛНЫ 1882 ОНЫ ХӨДӨЛГӨӨН

(Архивын баримтаас)

Г. Дашням, Ч. Уранчимэг

XIX—XX зууны заагт манжийн төрийн монгол орныг захиран баримтлах уламжлалт бодлого аажмаар хувьсан улам хөнөөлт харгис шинжтэй болсон нь монголын ард түмнийг үндэс угсаа, газар нутгаа хамгаалан, туурга тусгаар төр улсаа сэргээн байгуулахын төлөө эрслэн тэмцэхэд хүргэжээ. XIX зууны дэд хагасаас Монголын хот суурин газрын хөгжил түргэсч, хүн ам нь нэмэгдсэнээр улс орны амьдралд гүйцэтгэх үүрэг нь ихээхэн дээшлэв. Хотууд шашин, соёлын төв төдийгүй эдийн засаг, улс төрийн төв, нийгмийн хөгжлийн зөрчил тэмцлийн гол талбар болон хувирч байв. Манж Чин улсын сүүлийн улиралд хотын хүн амаас явуулсан тэмцэл нь ардын тэмцэлд гарсан шинэ үзэгдэл байлаа. Бидэнд мэдэгдэж байгаагаар, Монголын хотын хүн амаас хятадын мөлжимтгий худалдаачид, манжийн төлөөний сайд, түшмэдүүдийн эсрэг хийсэн анхны томоохон тэмцэл 1882 онд гарчээ. Архивын баримтаас үзвэл, Бадаргуулт төрийн 7 оны арван хоёр сарын шинийн 2 (1882 оны нэгдүгээр сарын 21) -нд Их Хүрээний баруун захад орших Лүн Шэн Гау хэмээх пүүсний иргэд хэдэн өдрийн өмнө наймаалцахад худалдан авсан барааны үнийг төлөлгүй зайлсан Сайн ноён хан аймгийн Мэргэн гүний хошууны лам Лувсангомбо гэгчийг Шүтээний аймгийн газраас олж бариад тамгын газар тушаахаар авч явтал, тэр хятад пүүсний газар очиж занчилдсугай хэмээн зээлийн газар хурсан олныг уриалжээ. Лам, хар олон хүн түүний үгийг даруй зөвшөөрч 300, 400 хүн нийлж Лүн Шэн Гау пүүсний хашаа байшинг эвдлэн орж, иргэдийг чулуугаар занчин, эд барааг нь талан дээрэмдсэн байна.¹ Зээлийн газар Их Хүрээг цагдан сэргийлэх үүрэг хүлээсэн Түшээт хан, Сэцэн хан, Шавь гурван газрын цагдаа нар байсан боловч үймэн боссон олныг хориглон зогсоохыг оролдсонгүй.² Хүрээний ард олон хэдэн зуугаараа нийлэн түрхрэн хөдөлж, хятад худалдааны пүүсийг өдрөөр талан дээрэмдсэн, Хүрээг сэргийлэх монгол цагдаа түүнийг хориглон зогсоолгүй, битүү дэмжин сул орхин хөгжөөсөн нь Хүрээний манж сайдыг сандаргажээ.

Тухайн үед Баруун Монголд гарсан цагаан малгайтны бослогын дуулиан тасарч амжаагүй, манжийн ноёрхолд дургүйцэх явдал түүний бүрэлдэхүүнд багтсан олон үндэстэн ястны дотор хүчтэй байсан цаг билээ. Жил гаруйхны өмнө Улиастайд сэргийлэн суулгасан монгол цэргүүд манжийн цэргийн албыг хаяж тэмцсэн. Иймд Хүрээний манж сайд эл хэргийг шийтгэхдээ ард олны дургүйцэл тэмцлээс сэргийлэн ихэд болгоомжтой ханджээ.

Хүрээний манж сайдын газраас Эрдэнэ шанзудбын яам, Түшээт хан, Сэцэн хан аймгийн чуулганы даргын газарт тушаан илгээсэн бичигт, монголчууд хятад пүүсний «байшин гэрийн үүд цонхыг эвдэж ороод эд барааг дураар булаан дээрэмдэж үнэхээр цаазгүй муу харгисын туйлд хүрсэн бөгөөд эдүгээ ягштал байцааж бариулаад цээрлэл үзүүлж шийтгэхгүй болбоос улс гүрэнд энэ мэт будлиан самуун хүнд хэрэг гарч болзошгүй» хэмээн заагаад, пүүсийг талан дээрэмдэх үед баригдсан Лувсангомбо, Дамба нарын таван хүнээс гадна тэргүүлэн явагсдыг «урьд адил дэмий хоосон нэр бичиж, нэгэнтэйгүүр хэрэг хэ-

рүүл гаргуулахад хүргэхгүй болгож магад сэтгэлээр сэргийлэн байцааж» нэг хэмээн дутаалгүй олж барин эрүүдэн шүүхэд бэлтгэх, харьяат хошуунд нь тушааж, урьд баригдагсдыг сахиулах дарга, цэрэг, хэрэглэл хүнсийг гаргуулан Их Хүрээнд түргэн ирүүлж батлан сахиулах, хэрэв өдөр алгуурлан хэрэгт холбогдогсдыг оргон зайлахад хүргэвэл харьяат шанзудба, чуулганы дарга нарыг байцаан шийтгэхээр тушаажээ. Мөн хойшид олон лам нар цугларан хэрүүл будлиан гаргахад хүргэх аваас харьяат түшмэд, цагдаа нар Эрдэнэ шанзудбын яаманд даруй мэдэгдэж ихэс лам нарыг гаргах тухайд хориглон зогсоож байх явдлыг журам болгон дагаж шийтгүүлэхээр тогтоожээ.³

Тийнхүү Хүрээний манж сайдын газраас удаа дараа чангалан тушаасан боловч Хүрээний Эрдэнэ шанзудба, Түшээт хан, Сэцэн хан аймгийн чуулганы даргын газраас цагдан сэргийлэх түшмэл цэрэг, албаны хүмүүсийг гаргаж сурвалжлан эрүүлсэн боловч нэг ч хулгайг олж барьж чадсангүй хэмээн гэдрэг ягштал мэдүүлсэн байна.⁴ Иймд урьд баригдагсад, зээлийн газар байсан цагдаа нарыг шүүн байцааж, Лувсангомбо, Дамба нарыг хоёр сар дөнгө өмсгөхөөр таслан шийтгэж, бусдыг хэрэгт холбогдолгүй хэмээн сул тавьжээ.⁵

Гэтэл Лүн Шэн Гау пүүсний иргэд пүүсийг талан дээрэмдэж, иргэдийг занчсан хүмүүсийг бүрэн барьж шийтгээгүй, учирсан хохирлыг төлүүлээгүй хэмээн дахин заалдсан байна.⁶ Хүрээний манж сайдын газраас энэ удаа Эрдэнэ шанзудбын яам, зүүн хоёр аймгийн чуулганы даргын газарт «жинхэнэ хулгайч»-ийг 5 сарын шинийн нэгний дотор яаралтай олж барихыг хугацаалан тушаасан боловч талаар өнгөрчээ.⁷ Эцэст пүүсний алдагдсан эд барааны үнийг дурдсан гурван газраас төлүүлж, хэрэгт холбогдогсдыг бүрэн барьж олсон цагт жич нөхөн олгуулахаар зөвшиж, урьдаар алдагдсан барааны үнийн хоёр хувь болох 600 ланг гурван газраас хуваан гаргуулахаар тогтжээ.⁸

Их Хүрээний ард олны энэ тэмцлийг өнгөцхөн харахад худалдаа наймааны хэргээс үүдсэн жирийн будлиан мэт санагдавч угтаа улс төрийн гүнзгий учир холбогдол бүхий үйл явдал байв. XIX зууны эцсээр манжийн төрийн бодлогод хятад түшмэдийн гүйцэтгэх үүрэг, нөлөө нь ихэд өсөж, манжийн төрийн бодлого нь хэрэг дээрээ хятадын шинээр төрж буй хөрөнгөтөн, үйлдвэр худалдаа, газрын эздийн ашиг сонирхлыг улам бүр илэрхийлэх болсон. Энэ нь хятад худалдаачдын мөлжлөгийг эсэргүүцсэн ардын тэмцэлд хүчтэй нөлөөлж, тэр нь манжийн төрийн бодлоготой зөрчилдөхөд хүргэжээ. Үүний нэг илрэл нь Их Хүрээний лам, хар ард олны 1882 оны хөдөлгөөн мөн.

Хятад худалдаачдын мөлжлөгийг эсэргүүцэн олон зуун хүн зэрэг босон тэмцэж, тэр тэмцлийг Эрдэнэ шанзудбын яам, Түшээт хан, Сэцэн хан аймгийн чуулганы даргын газар, Их Хүрээг цагдан сэргийлэх монгол түшмэд, цагдаа нар битүү дэмжин хамгаалсан нь хятад худалдаачдын мөлжлөг, түүнийг ивээгч манжийн төрийн бодлогод дургүйцэх явдал Монголын ард түмний дотор нийтийг хамарсан шинжтэй, хүчтэй болсоныг харуулав.

Манжийн төлөөний сайд, түшмэдээс хятад худалдаачид, монголчуудын зөрчил тэмцлийг хурцатгахгүйгээр эл хэргийг таслан шийтгэж, цаашид энэ мэт үймээн хөдөлгөөнөөс сэргийлэх арга замыг бий болгохыг оролдсон боловч амжилт олсонгүй. Нэг талаас хятад худалдаачид, манжийн төлөөний сайд түшмэд, нөгөө талаас Их Хүрээний ард олны хооронд зөрчлийн үр хуримтлагдсаар Их Хүрээний лам, хар ард олны 1905, 1909, 1910 оны хөдөлгөөн гарахад хүргэжээ.

Монголын ард түмний үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болсон хотын хүн амын эдгээр тэмцэл хөдөлгөөн нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг бэлтгэн явуу-

лахад чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Их Хүрээний лам, хар ард олны 1882 оны тэмцэл нь тэрхүү хөдөлгөөнүүдийн эхлэлийг тавьжээ. Чухам үүнд эл хөдөлгөөний ач холбогдол оршино.

1. УТТА. ФМ-I, Д-I, ХН—1878, х, 257 — 259
2. УТТА Ф—I, Д-1, ХН—1897, х.39
3. УТТА ФМ-I, Д-1, ХН—1878, х.259—261
4. УТТА ФМ ---I, ХН—1897, х.34—42, ФМ-85, Д-1, ХН-639, х. 13-16
5. УТТА. ФМ-1, ХН—1897, х 41, ФМ-9, ДНI, ХН-3117, х 19
6. УТТА. ФМ —I, Д-I, ХН—1897, х 42
7. УТТА. ФМ-1, (Д-1, ХН—1897, х.42, ФМ-85, Д-1, ХН-669, х 13-16 100—101
8. УТТА. ФМ-85, Д-I, ХН—639, х.124

**«ДОРНОДАХИНЫ СУДЛАЛ» СЭТГҮҮЛД 1990 ОНД
ХЭВЛЭГДСЭН МАТЕРИАЛЫН АГУУЛГА**

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

- Л. Бат-Очир, д. Уламбаяр.** Жамсрангийн Цэвээний социализмын тухай үзэл. 1990. № 1 (22)
- Ц. Пүрэвжаргал.** Социализм, өөрчлөн байгуулалтын тухай Хятадын эрдэмтдийн үзэл баримтлал 1990. № 1 (22)
- Д. Баясгалан,** Хятадын нийгэм-эдийн засгийн шинэчлэлтийн зарим асуудал, туршлага. 1990 № 1 (22)
- Х. Хулан.** Ази-Номхон далайн бүс нутаг дахь АНУ-ын бодлого, залгамж чанар, шинэ зүйл. 1990 No 1 (22)
- Ж. Бямбасүрэн.** БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ ба Монгол, Хятадын харилцааны өнөөгийн байдал. 1990. № 2 (23)
- Д. Дүнгэр-Яйчил.** Монгол-Японы харилцаа: Зүүн хойт Азийн олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэг. 1990 № 2 (23)
- ЭДИЙН ЗАСАГ**
- Ч. Сувд.** Шинээр аж үйлдвэржсэн азийн орнуудын туршлага, сургамж 1990, № 1 (22)
- С. Жаргалсайхан,** Эдийн засгийн онцгой бүс-Хайнань. 1990. № 1 (22)
- З. Эрдэнэчимэг.** Социалист чиг баримжаат орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд үндэсний боловсон хүчний үүрэг 1990. № 1 (22)
- Б. Лхагваа.** БНСУ-ын хөгжлийн зарим онцлог, «шинээр үйлдвэржсэн орнууд»- ад эзлэх байр суурь. 1990 № 2 (23)
- ТҮҮХ, СОЁЛ, БОЛОВСРОЛ, ШАШИН**
- Д. Цэдэв.** Монголын хаадын түүхээс. 1990 № 1 (22)
- С. Дашцэвэл.** Монгол-Вьетнамын элчин харилцааны түүхээс 1990 № 1
- Л. Жамсран.** МАХН Хятадын 1924—1927 оны хувьсгалыг дэмжиж байсан нь. 1990 № 1 (22)
- Н. Дашзэвэг.** Жал-зээ-тэм-бан буюу нүхэт бичмэл ганжуурын тухай. 1990. № 1 (22)
- Р. Бямбаа,** «Дэмбэрэлдодва» хэмээх зохиолын монгол орчуулга, тайлбарын асуудалд. 1990 № 1 (22)
- Ж. Баттөр.** Зарим хятад романы монгол орчуулгын тухайд. 1990 № 1 (22)
- Д. Жамсранжав.** Санаа бичиг судлалд. 1990 № 1 (22)
- Я. Ганбаатар.** Хятад хэлний мэндлэх, золгох, салж хагацах зарим үг хэллэгийн тухай. 1990. № 1
- М. Зэнээ.** Эрх чөлөөний тэмцлийн түүх аман зохиолын холбогдол, 1990. № 1 (22)
- А. Дашдэмбэрэл.** Манжийн үеийн монголын ноёдын зэрэг хэргэм 1990. № 1 (22)